



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/381

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.4 зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн аюулгүйн нөөцөд малын тэжээл худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	О.Сэдэд	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Гишүүн:	Ү.Баяржаргал	-Онцгой байдлын газрын нярав

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Э. Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА